



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/32/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Аудитор: Ж.Бүжинханд
Утас: 261740 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК
Захирал: Ч.Энхтуяа
Цахим хаяг: enkh TUYA@hlb.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ
ТЭМЦЭХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Г.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2024.02.29 № 07/601
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл нь цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн 3,000.0 мянган ам.долларын үндсэн санхүүжилт, 1,000.0 мянган ам.долларын нэмэлт санхүүжилт, нийт 4,000.0 мянган ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах үйл ажиллагааг явуулсан байна.

Азийн хөгжлийн банкнаас төслийн үндсэн санхүүжилтийн 3,000.0 мянган ам.доллараас 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өссөн дүнгээр нийт 2,992.0 мянган ам.доллар буюу 99.7 хувь, нэмэлт 1,000.0 мянган ам.долларын санхүүжилтээс 0,712.0 мянган ам.долларын санхүүжилтийг авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Сонгинохайрхан дүүрэгт шинээр барих Түр хамгаалах байрны барилгын ажил (W014) 2023 оны 5 дугаар сард бүрэн дуусаж, 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын комисс ажиллаж, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн удирдлагын гарын авлагад тусгасны дагуу төслийн нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлэх бүх арга хэмжээг 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тайлант онд 3,992.0 мянган ам.доллар зарцуулсан нь нийт төлөвлөгөөний 99.8 хувь байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,176,483,563.95	1,402,611,628.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,563,229,998.17	232,960,162.28
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,563,229,998.17	232,960,162.28
31210	Төгрөг	1,098,832,711.89	226,253,449.67
31211	Төрийн сангийн харилцах	1,098,832,711.89	226,253,449.67
31220	Гадаад валют	464,397,286.28	6,706,712.61
31221	Төрийн сангийн харилцах	464,397,286.28	6,706,712.61
33	АВЛАГА	221,247.27	3,284,758.52
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	221,247.27	3,284,758.52
34	УРЬДЧИЛГАА	39,005.00	39,005.00
34600	Урьдчилж гарсан зардал	39,005.00	39,005.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	612,993,313.51	1,166,327,702.96
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	612,993,313.51	1,166,327,702.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	47,710,045.45	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	47,710,045.45	-
39200	Биет хөрөнгө	45,483,528.33	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	73,821,605.00	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,359,072.13)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,357,390.00	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,336,394.54)	-
39300	Биет бус хөрөнгө	2,226,517.12	-
39301	Программ хангамж	9,295,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,068,482.88)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,224,193,609.40	1,402,611,628.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,471,388.05	24,771,819.42
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,471,388.05	24,771,819.42
41300	Өглөг	16,471,388.05	24,771,819.42
41360	Бусад өглөг	16,471,388.05	24,771,819.42
41361	Байгууллагад төлөх өглөг	46,000.00	12,046,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	52,179.00	211,277.87
	НДШ-ийн өглөг	-	206,250.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	16,373,209.05	12,308,291.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,207,722,221.35	1,377,839,809.34
51	Засгийн газрын хувь оролцоо	2,207,722,221.35	1,377,839,809.34
51200	Хуримтлагдсан үр дүн	2,207,722,221.35	1,377,839,809.34
51210	Өмнөх үеийн үр дүн	400,911,765.23	2,207,722,221.35
51220	Тайлант үеийн үр дүн	1,806,810,456.12	(829,882,412.01)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,224,193,609.40	1,402,611,628.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,216,485,470.33	5,488,827,467.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,216,485,470.33	5,488,827,467.36
120	Нийтлэг татварын бус орлого	143,635,088.80	8,807,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	143,635,088.80	8,807,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	143,635,088.80	-
1200047	Бусад орлого	-	8,807,000.00
122	Тусламжийн орлого	4,072,850,381.53	5,480,020,467.36
122002	Хандив тусламж /гадаад/	4,072,850,381.53	5,480,020,467.36
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,068,726,895.24	3,791,740,908.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,068,726,895.24	3,791,740,908.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,068,726,895.24	3,791,740,908.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,390,726.60	272,286,064.32
210101	Үндсэн цалин	346,390,726.60	272,286,064.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,866,455.07	34,233,955.42
210201	Тэтгэврийн даатгал	42,866,455.07	34,233,955.42
2104	Хангамж, бараа материалын зардал	16,121,439.37	20,283,850.72
210401	Бичиг хэрэг	10,932,659.98	15,964,416.26
210402	Тээвэр, шатахуун	2,381,108.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,807,671.39	2,819,434.46
2107	Томилолт, зочны зардал	31,543,270.17	26,273,500.00
210702	Дотоод албан томилолт	31,543,270.17	26,273,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,606,990,113.80	2,432,592,044.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,606,668,740.55	2,432,073,015.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	321,373.25	519,028.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,814,890.23	1,006,071,493.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	982,346,705.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,814,890.23	23,724,788.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,147,758,575.09	1,697,086,558.86
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	87,740,722.83	-
145000	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	87,740,722.83	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	428,688,841.80	2,526,968,970.87
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	6,075,620.49
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	143,635,088.80	23,985,256.53
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	285,053,753.00	2,496,908,093.85
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,806,810,456.12	(829,882,412.01)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,072,850,381.53	5,500,827,467.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,072,850,381.53	5,500,827,467.36
120	Нийтлэг татварын бус орлого	-	20,807,000.00
120009	Бусад орлого	-	20,807,000.00
122	Тусламжийн орлого	4,072,850,381.53	5,480,020,467.36
122002	Хандив тусламж /гадаад/	4,072,850,381.53	5,480,020,467.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,039,454,105.23	3,774,779,199.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,039,454,105.23	3,774,779,199.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,039,454,105.23	3,774,779,199.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,384,607.69	277,103,574.28
210101	Үндсэн цалин	330,384,607.69	277,103,574.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,346,325.38	33,837,226.54
210201	Тэтгэврийн даатгал	33,106,665.88	23,009,314.04
210202	Тэтгэмжийн даатгал	3,894,901.89	2,706,978.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,115,921.51	2,165,582.48
210204	Ажилгүйдлийн даатгал	748,076.01	541,395.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,480,760.09	5,413,956.26
2104	Хангамж, бараа материалын зардал	16,887,819.37	20,150,579.00
210401	Бичиг хэрэг	10,932,659.98	14,968,416.26
210402	Тээвэр, шатахуун	3,147,488.00	2,496,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,807,671.39	2,686,162.74
2107	Томилолт, зочны зардал	31,543,270.17	17,273,500.00
210702	Дотоод албан томилолт	31,543,270.17	17,273,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,612,292,082.62	2,513,938,253.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,612,292,082.62	2,513,938,253.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	912,476,066.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	912,476,066.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,033,396,276.30	1,726,048,267.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	890,135,606.00	3,050,242,483.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	890,135,606.00	3,050,242,483.30
2200	Дотоод эх үүсвэрээр	890,135,606.00	3,050,242,483.30
220001	Барилга байгууламж	605,081,853.00	257,607,033.13
222001	Тоног төхөөрөмж	285,053,753.00	2,792,635,450.17
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(890,135,606.00)	(3,050,242,483.30)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	87,740,722.83	(6,075,620.49)
14	Бусад эх үүсвэр	87,740,722.83	
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	87,740,722.83	
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	6,075,620.49
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	6,075,620.49
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,231,001,393.13	(1,330,269,835.89)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	332,228,605.04	1,563,229,998.17
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,563,229,998.17	232,960,162.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	400,911,765.23	400,911,765.23
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	400,911,765.23	400,911,765.23
Тайлант үеийн үр дүн			1,806,810,456.12	1,806,810,456.12
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,207,722,221.35	2,207,722,221.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,207,722,221.35	2,207,722,221.35
Тайлант үеийн үр дүн	-	-	(829,882,412.01)	(829,882,412.01)
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	1,377,839,809.34	1,377,839,809.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,048,769,200.00	6,825,021,682.76	1,223,747,517.24	84.8
УРСГАЛ ЗАРДАЛ	4,362,625,000.00	3,774,799,199.46	587,825,800.54	86.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,362,625,000.00	3,774,799,199.46	587,825,800.54	86.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,130,700.00	277,103,574.28	1,027,125.72	99.6
Үндсэн цалин	278,130,700.00	277,103,574.28	1,027,125.72	99.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,838,800.00	33,837,226.54	1,573.46	100.0
Тэтгэврийн даатгал	23,009,700.00	23,009,314.04	385.96	100.0
Тэтгэмжийн даатгал	2,707,300.00	2,706,978.12	321.88	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,165,600.00	2,165,582.48	17.52	100.0
Ажилгүйдлийн даатгал	541,700.00	541,395.64	304.36	99.9
Эрүүл мэндийн даатгал	5,414,500.00	5,413,956.26	543.74	100.0
Хангамж, бараа материалын зардал	22,655,000.00	20,150,579.00	2,504,421.00	88.9
Бичиг хэрэг	15,614,000.00	14,968,416.26	645,583.74	95.9
Тээвэр, шатахуун	2,496,000.00	2,496,000.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,545,000.00	2,686,162.74	1,858,837.26	59.1
Томилолт, зочны зардал	17,500,000.00	17,273,500.00	226,500.00	98.7
Дотоод албан томилолт	17,500,000.00	17,273,500.00	226,500.00	98.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,668,713,400.00	2,513,938,253.57	154,775,146.43	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,668,713,400.00	2,513,938,253.57	154,775,146.43	94.2
Бараа ажил үйлчилгээний бусад зардал	1,341,787,100.00	912,476,066.07	429,311,033.93	68.0
Бараа ажил үйлчилгээний бусад зардал	1,341,787,100.00	912,476,066.07	429,311,033.93	68.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,686,144,200.00	3,050,242,483.30	635,901,716.70	82.7
Барилга байгууламж	342,232,900.00	257,607,033.13	84,625,866.87	75.3
Тоног төхөөрөмж	3,343,911,300.00	2,792,635,450.17	551,275,849.83	83.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,048,769,200.00	5,480,020,467.36	2,568,748,732.64	68.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	8,048,769,200.00	5,480,020,467.36	2,568,748,732.64	68.0
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	8,048,769,200.00	5,480,020,467.36	2,568,748,732.64	68.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,563,229,998.17		
Төсвийн тохируулга		14,731,379.51		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		232,960,162.28		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	11	5	(6)	
Удирдах ажилтан	1	1	-	
Гүйцэтгэх ажилтан	10	4	(6)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,574,343.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 7 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 229.2 мянган төгрөгөөр дутуу тооцоолж тайлагнасан;
- Нягтлан бодох бүртгэлд 123,474.0 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг 24,278.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн ;
- Санхүүгийн байдлын тайлангийн дансны өглөгийн эхний үлдэгдлийг 39.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Санхүү үр дүнгийн тайлангийн Хандив тусламжийн орлогыг 3,050,242.5 мянган төгрөгөөр илүү бүртгэж тайлагнасан;
- Цагдаагийн ерөнхий газарт 761,848.2 мянган төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 253,409.7 мянган төгрөгийн, Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 648,539.8 мянган төгрөгийн, Нийслэлийн цагдаагийн удирдах газарт 512,764.8 мянган төгрөгийн, СХД-ийн ТХБ-д 311,631.9 мянган төгрөгийн, ГХУСАЗ зөвлөлд 8,713.6 мянган төгрөгийн бусад хөрөнгийг тус тус хүлээлгэн өгснийг бүртгэлээс хасаагүй;
- Санхүү үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 2,614.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлж, өмнөх үеийн үр дүнг бууруулж бүртгэсэн ;
- Ажилчдын гарт олгох цалинг 31.3 мянган төгрөгөөр илүү олгосон;

Аудитаар нийт 5,681.4 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснийг давтан гаргахгүй, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар 1 зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 5,681.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 63,187.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Ерөнхий журнал, Мөнгөн хөрөнгийн журналаас 5,112,322.2 мянган төгрөгийн 167 ажил гүйлгээг цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 5,681.4 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээ и-баримтаар баталгаажуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил үйлчилгээний төлбөрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 229.2 мянган төгрөгөөр дутуу тооцоолж тайлагнасан.	1	229.2			1	229.2	1	229.2				
Нягтлан бодох бүртгэлд 123,474.0 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг 24,278.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн .	1	24,278.6			1	24,278.6	1	24,278.6				
Санхүүгийн байдлын тайлангийн дансны өглөгийн эхний үлдэгдлийг 39.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн .	1	39.0			1	39.0	1	39.0				
Санхүү үр дүнгийн тайлангийн Хандив тусламжийн орлогыг 3,050,242.5 мянган төгрөгөөр илүү бүртгэж тайлагнасан .	1	3,050,242.5			1	3,050,242.5	1	3,050,242.5				
Цагдаагийн ерөнхий газарт 761,848.2 мянган төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 253,409.7 мянган төгрөгийн, Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 648,539.8 мянган төгрөгийн, Нийслэлийн цагдаагийн удирдах газарт 512,764.8 мянган төгрөгийн, СХД-ийн ТХБ-д 311,631.9 мянган төгрөгийн, ГХУСАЗ зөвлөлд 8,713.6 мянган төгрөгийн бусад хөрөнгийг тус тус хүлээлгэн өгснийг бүртгэлээс хасаж тайлагнаагүй байна.	1	2,496,908.1			1	2,496,908.1	1	2,496,908.1				
Санхүү үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 2,614.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлж өмнөх үеийн үр дүнг бууруулж бүртгэсэн .	1	2,614.6			1	2,614.6	1	2,614.6				
Ажилчдын гарт олгох цалинг 31.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1	31.3			1	31.3	1	31.3				
Дүн	7	5,574,343.2	-	-	7	5,574,343.2	7	5,574,343.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн гүйлгээний зардлын нийт 5,112,322.2 мянган төгрөгийн гүйлгээг цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 5,681.4 мянган төгрөгийн зардлын гүйлгээнд и-баримт бүртгэгдээгүй байна	1	5,681.4					1	5,681.4				
	Дүн	1	5,681.4	-	-	-	-	1	5,681.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд нийт 11,015,154.3 мянган төгрөгийн 141 мэдээллийг ил тод байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,492,020.5 мянган төгрөгийн 13 мэдээлэл, зарлагын 1,907,300.2 мянган төгрөгийн 14 мэдээллийг тус тус байршуулаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.	1	7,399,320.7			1	7,399,320.7		-
	Дүн	1	7,399,320.7	-	-	1	7,399,320.7	-	-